ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/11 Сайншанд

Сайн төрийн албан хаагч дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дах хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Сайн төрийн албан хаагч" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013023

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/11 дүгээр тогтоолын нэгдүгээр
хавсралт

САЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалт

1.2. "Алсын хараа-2050" Монгол Улсыг урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн "Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба" Зорилт 5.4 Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлэх заалт;

1.3. Аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл;

1.4. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн 5.1.2.9, 5.1.2.8 дахь заалт;

1.5. Сэврэй сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын өсөлт" заалтыг хэрэгжүүлэх.

Хоёр. Хэрэгцээ шаардлага

2.1. Сумын хүн ам өнөөгийн байдлаар 2000 орчим болж, төрийн үйлчилгээний шинэ
соёл, арга хэлбэрүүд нэмэгдэж байгаа нь төрийн албан хаагчдыг хариуцлагатай байх, тэднийг хөгжүүлэх, төрийн албаны ёс зүйг чанд сахиулах, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, сурч хөгжихөд хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлдэг байх шаардлагатай байна.

2.2. Төрийн болон нутгийн захиргааны бүх байгууллагууд үйл ажиллагаандаа стандарт нэвтрүүлэх зорилт тавьсан бөгөөд байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, ажлын уялдаа холбоо сайжрах, баримт бичиг эмх цэгцтэй болох, ажлын давхардал хийдэл, хүнд суртлыг арилгах, албан хаагчдын мэдлэг ур чадвар, бүтээмжийг тасралтгүй ахиулах, улмаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх боломж бүрдэнэ.

2.3. Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хурдан шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх, албан хаагчдын мэдлэг чадвар, сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах, албан үүргээ гүйцэтгэх сэтгэл ханамж, урам зоригыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага нэн чухал байна.

2.4. Нөгөө талаас сүүлийн жилүүдэд залуу боловсон хүчин ихээр нэмэгдэж байгааг харгалзан тэдний ажиллах нөхцөл бололцоог орчин үеийн шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлэх, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, байгууллагын хүний нөөцнйг бэхжүүлэх, хариуцлагатай төрийн албан хаагчдыг дэмжин хөгжүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байна.

2.5. 2020-2024 онд "Сайн төрийн албан хаагч хөтөлбөр" хэрэгжиж төрийн

албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дэмжиж, албан хаагчдын мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд нь дэмжлэг үзүүлэн үр дүнтэй хэрэгжсэн.

Гурав. Хамрах хүрээ

Энэхүү хөтөлбөрт тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, харьяалал бүхий босоо удирдлагатай албан хаагчид, төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагын албан хаагчид, бусад хот, аймаг, сумаас урилгаар болон, гэрээгээр орон нутагт тогтвортой ажиллах нарийн мэргэжлийн, өндөр ур чадвартай төрийн албан хаагчид хамрагдана.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мерит буюу чадахуйн зарчмыг бүхий л шатанд мөрдөх, албан хаагчийн ажиллах таатай орчин, урам зориг, хүсэл эрмэлзлэлийг бий болгоход чиглэгдсэн, хөдөлмөрийн харилцаан дахь урамшуулал, идэвхижүүлэлтийн аргад тулгуурласан олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар чадварлаг мэргэшсэн ажил горилогчдыг өөртөө татах, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай, ур бүтээлтэй ажиллуулах, хариуцлагатай, чадвартай мэргэшсэн төрийн албан хаагчийг ажиллуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Тав. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах 3 зорилтыг дэвшүүлж ажиллана.

5.1. Шударга хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний соёл, чанар, хүртээмж, шуурхай байдлыг шинэ шатанд гаргах

5.2. Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, манлайлал, ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг сайжруулах

5.3. Сайн төрийн албан хаагч хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлсэн байгууллага, хамт олон, албан хаагчийг дэмжиж, урамшуулах.

Зургаа. Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

6.1.Нэгдүгээр зорилтын хүрээнд: Шударга хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний соёл, чанар, хүртээмж, шуурхай байдлыг шинэ шатанд гаргах;

6.1.1. Иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдолд хуулийн хугацаанд тодорхой хариу өгч, үйлчилгээний найрсаг, эерэг хандлагыг бий болгоно.

6.1.2. Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид иргэний үүргийнхээ дагуу багийн Иргэдийн Нийтийн Хуралд биечлэн оролцож, иргэдийн санал хүсэлтийг сонсож, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ.

6.1.3. Төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, иргэд, иргэний нийгмийн байгууллага, бизнес эрхлэгчдэд чанартай, соёлтой, хүртээмжтэй, хүнд сурталгүй, авлигагүй үйлчилгээ үзүүлэх зорилтыг бүх талаар хангаж ажиллана.

6.1.4. Төрийн байгууллагууд “Хөтөч” үйлчилгээг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан нэвтрүүлнэ.

6.1.5. Төрийн үйлчилгээний хүнд суртал, алдаа дутагдал гаргаж, ажилд нь өөрчлөлт дэвшил гарахгүй байгаа албан байгууллага болон түүний удирдлага, ажилтан, албан хаагчдын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт, үнэлгээ хийж,

шаардлагатай тохиолдолд холбогдох хууль дүрэм, журмын дагуу хариуцлага тооцож ажлыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд: Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, манлайлал, ёс зүй, харилцаа, хандлага, хариуцлагыг сайжруулах

6.2.1. Төрийн албан хаагчдын манлайлал, ёс зүй, соёл, харилцаа, хандлагыг дээшлүүлэх чиглэлд танхимын сургалтуудыг зохион байгуулна.

6.2.2. Төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй гүйцэтгэх ажлын байрны дэг журмыг чанд сахих талаар ажлын байранд нь дадлагажуулах арга зүйн сургалтуудыг тогтмолжуулна.

6.2.3. Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн албан хаагчийн манлайлал, харилцаа, хандлага, ёс зүй, үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн хангах тухай тодорхой тусгаж, гэрээг дүгнэх үзүүлэлт болгож хэвшинэ.

6.2.4. Төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлж, чадавхжуулах танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.

6.2.5. Төрийн албан хаагчдыг ажил үүргийн чиглэлийн дагуу гадаад, дотоодын сургалт семинар, зөвлөгөөн, туршлага судлах арга хэмжээнүүдэд хамруулж, чадавхжих, мэргэшиж суралцах нөхцөлөөр хангана.

6.2.6. Төрийн албан хаагчдын дунд мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн зорилтот арга хэмжээг зохион байгуулна.

6.2.7. Албан хаагч нь хугацаатай болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй, удирдлагын чөлөө зөвшөөрөлгүй ажлын цагаар ажил цалгардуулсан, төрийн албаны хууль бусад дүрэм, журмыг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан сахилгын шийтгэлийг Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ноогдуулж хариуцлага хүлээлгэнэ.

6.3. Гуравдугаар зорилтын хүрээнд: Сайн төрийн албан хаагч хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлсэн байгууллага, хамт олон, албан хаагчийг дэмжиж, урамшуулах.

6.3.1. Тэргүүний байгууллага шалгаруулах арга хэмжээний үндсэн үзүүлэлт нь энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн байх бөгөөд жил бүр төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж Сумын “Алтан шаргал элс” шагналаар шагнах.

6.3.2. Мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд нь сургалтын төлбөр, унаа, бусад зардлын дэмжлэг үзүүлнэ.

6.3.3. Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, мэргэжлийнхээ дагуу нийтэд хэрэгцээтэй оюуны бүтээл туурвих, туршлага болохуйц ажил үйлчилгээг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлж болно.

6.3.4. Албан хаагчдыг Улаанбаатар хотын нарийн мэргэжлийн эмнэлгүүд, аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.

6.3.5. Дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай төрийн албан хаагчид өвчний онош, эмчлүүлэх хугацаа эмчилгээний төлбөрөөс хамааран эмчилгээний зардлын тусламж үзүүлнэ.

6.3.6. Сум орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж амьдарч буй албан хаагчдад дэмжлэг үзүүлнэ.

6.3.6.1. Орон нутагт дутагдалтай мэргэжилээр ирж ажиллаж буй нарийн мэргэжлийн өндөр ур чадвартай албан хаагчийг малжуулна. /Ажлын үр дүнг харгалзан, 5 жил тогтвор суурьшилтай ажилласан/

6.3.6.2. Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй албан хаагч болон шинэ боловсон хүчнийг орон сууцаар хангана.

6.3.6.3. Төрийн албанд дутагдалтай мэргэжилээр гадаад дотоодын их сургуульд суралцаж буй оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.

Долоо. Төрийн албан хаагчийн баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээ

7.1. Төрийн албан хаагч бүр албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргээ мэргэжлийн өндөр түвшинд Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд шударгаар гүйцэтгэх зарчим баримтална.

7.2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудаас гаргаж буй аливаа шийдвэр, үйлчилгээ нь хууль, тогтоомжид нийцсэн байна.

7.3. Иргэдээс аливаа зүйлийг нуун дарагдуулан шийдвэр гаргахгүй байх, аливаа байдлаар саад учруулж, цаг алдагдуулахыг цээрлэнэ.

7.4. Албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ хэнийг ч ялгаварлаж хандахгүй байхын зэрэгцээ, хамт ажиллаж байгаа болон бусад хүмүүсийн эрхийг хүндэтгэх, төр засгаас хүлээлгэсэн итгэлийг дааж ажиллах зарчим баримтална.

7.5. Төрийн албаны удирдах ажилтны Улсын зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмж, Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх шатны төрийн албан хаагчид мөрдөж ажиллана.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт, удирдлага зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийг 2025-2028 онуудад хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт дараах эх үүсвэрээс
санхүүжүүлнэ.

8.2.1. Орон нутгийн төсөв

8.2.2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

8.2.3. Бусад эх үүсвэр

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг орон нутгийн төсвөөс зарцуулах бөгөөд байгууллагууд өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Хөтөлбөрийг удирдан зохион байгуулах, мэдээлэлээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг сумын Засаг даргын Тамгын газар хариуцан, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэнэ.

Ес. Хөтөлбөрийн үр дүн

9.1. Шударга хариуцлагатай, ил тод нийтийн алба бэхжиж, төрийн үйлчилгээний соёл, чанар, хүртээмж, шуурхай байдлыг шинэ шатанд гаргасан байна.

9.2. Үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн байгууллага, хамт олон, албан хаагчдын сахилга, хариуцлага сайжирсан байна.

9.3. Төрийн үйлчилгээний албан хаагчдын харилцааны соёл, харилцаа,

хандлага, хариуцлага, ёс зүйтэй холбоотой иргэд, олон нийтийн гомдол, мэдээлэл буурсан байна.

9.4. Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэж, шилэн дансны хууль тогтоомж хэрэгжсэн байна.

9.5. Хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, хэлэлцүүлэг зэрэг аливаа арга хэмжээний цаг ашиглалт сайжирсан байна.

9.6. Төрийн байгууллага, албан хаагчдын ёс зүй, соёл, харилцаа хандлага, хариуцлага дээшилж, төрд итгэх иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна.

9.7. Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулах замаар мэдлэг боловсролыг нь дээшлүүлснээр чадварлаг, мэргэшсэн хүний нөөц бүрдсэн байна.

9.8. Иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшлийнхэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжид сэтгэл ханамжтай, бодлого зорилтыг дэмждэг зөв эерэг хандлага төлөвшинө.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

10.1. Сумын Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжнь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг нэгтгэн, сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

10.2. Байгууллага бүр хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид ирүүлж хэвшинэ.

10.3. Байгууллага бүр иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч, дүнг нэгтгэн хэлэлцэж, тайландаа тусгаж, иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд ашиглаж хэвшинэ.

10.4. Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг тооцон, иргэдэд ил тод мэдээлнэ.

Арван нэг. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /оноор/			
			2024	2025	2026	2027	2028
1 дүгээр зорилтын хүрээнд							
1	Иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдолд хуулийн хугацаанд тодорхой хариу өгч, үйлчилгээний найрсаг, эерэг хандлагыг бий болгоно.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	98	98.6	98.7	98.9	99.0
2	Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид иргэний үүргийнхээ дагуу Багийн иргэдийн нийтийн хуралд биечлэн оролцож, иргэдийн санал хүсэлтийг сонсож, үйл ажиллагаандаа	Багийн ИНХ-д оролцсон албан хаагчдын тоо	400	450	500	550	600

3	Төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, иргэд, иргэний нийгмийн байгууллага, бизнес эрхлэгчдэд чанартай, соёлтой, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зорилтыг бүх талаар хангаж ажиллана.	Ил тод байдлын үнэлгээний хувь	80	85	90	95	100
4	Төрийн байгууллагууд, сумдын Засаг даргын Тамгын газарт "Хөтөч" үйлчилгээг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан нэвтрүүлнэ.	"Хөтөч" үйлчилгээ нэвтрүүлсэн байгуулл	0	5	5	5	5
5	Төрийн үйлчилгээний хүнд суртал, алдаа дутагдал гаргаж, ажилд нь өөрчлөлт дэвшил гарахгүй байгаа албан байгууллага болон түүний удирдлага, ажилтан, албан хаагчдын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль дүрэм, журмын дагуу хариуцлага тооцож ажлыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Сум, байгуулл агын тоо		5	5	5	5
2 дугаар зорилтын хүрээнд							
6	Төрийн албан хаагчдын манлайлал, ёс зүй, соёл, харилцаа, хандлагыг дээшлүүлэх чиглэлийн танхимын сургалтуудыг зохион байгуулна.	Сургалтын тоо	1	2	2	2	2
		Хамрагдсан албан хаагчдын тоо	94	94	94	94	94
7	Төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй гүйцэтгэх ажлын байрны дэг журмыг чанд сахих талаар ажлын	Сургалтанд хамрагдсан төрийн албан хаагч	94	94	94	94	94

8	Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн албан хаагчийн манлайлал, харилцаа, хандлага, ёс зүй, үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн хангах тухай тодорхой тусгаж, дүгнэх үзүүлэлт болгож хэвшинэ.	Дундаж үнэлгээ	80	85	87	89	92
9	Төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлж, чадавхжуулах танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.	Хамрагдалтын хувь	85	90	92	94	100
10	Төрийн албан хаагчдыг ажил үүргийн чиглэлийн дагуу гадаад, дотоодын сургалт, семинар, зөвлөгөөн, туршлага судлах арга хэмжээнүүдэд хамруулж, чадавхжиж, мэргэших нөхцөлөөр хангана.	Гадаад сургалтад хамрагдсан	2	2	2	2	2
		Дотоод сургалтад хамрагдсан тоо	40	50	70	80	90
11	Төрийн албан хаагчдын дунд мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн зорилтот арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	0	1	2	2	3
3 дугаар зорилтын хүрээнд							
12	Тэргүүний байгууллага, төрийн албан хаагчийг шалгаруулах арга хэмжээний үндсэн үзүүлэлт нь энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн байх бөгөөд жил бүр сонгон шалгаруулж шилдэг баг байгууллага, 9 алдартан, Сумын “Алтан шаргал элс” шагналаар шагнуулна.	Байгууллагын тоо	1	1	1	1	1
		Албан хаагчийн тоо	1	1	1	1	1

13	Мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд нь сургалтын төлбөр, унаа, бусад зардлын дэмжлэг үзүүлнэ.	Хамрагдсан албан хаагчийн тоогоор	1	1	2	2	2
14	Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, мэргэжлийнхээ дагуу нийтэд хэрэгцээтэй оюуны бүтээл туурвих, туршлага болохуйц ажил үйлчилгээг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлж болно	Хамрагдсан албан хаагчийн тоогоор	0	1	1	1	1
15	Албан хаагчдыг Улаанбаатар хотын нарийн мэргэжлийн эмнэлгүүд, аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.	Хамрагдсан албан хаагчийн тоогоор	-	60	65	70	75
16	Дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай төрийн албан хаагчид өвчний онош, эмчлүүлэх хугацаа эмчилгээний төлбөрөөс хамааруулан эмчилгээний зардалд тусламж үзүүлнэ.	Дэмжлэгийн тоогоор	-	1	2	1	2
17	Орон нутагт дутагдалтай мэргэжилээр ирж ажиллаж буй нарийн мэргэжлийн өндөр ур чадвартай албан хаагчийг малжуулна.	Хамрагдсан албан хаагчийн тоогоор	1	1	0	1	-
18	Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй албан хаагч болон шинэ боловсон хүчнийг орон сууцаар хангана.	Хамрагдсан албан хаагчийн тоогоор	2	2	2	2	2
19	Төрийн албанд дутагдалтай мэргэжилээр гадаад дотоодын их сургуульд суралцаж буй оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.	Хамрагдсан албан хаагчийн тоогоор	2	2	2	2	2

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
03/11 дүгээр тогтоолын хоёдугаар
хавсралт

САЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд: Д.Бямбадэлгэр (Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Ерөнхий боловсролын сургуулийн захирал

20 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Соёлын төвийн эрхлэгч

Дэмд-Од орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

Засаг дарга Тамгын газрын Санхүү албаны дарга

Нарийн бичиг: Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүй хариуцсан мэргэжилтэн

-oOo-